



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 4/180

Номгон


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Сангийн сайдын 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагдаагийн газрын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа Ланд круйзер-200 маркын 00-02 БНХ улсын дугаартай тээврийн хэрэгслийн засварт 7,182,000 (долоон сая нэг зуун наян хоёр мянган төгрөг) зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

2. Тээврийн хэрэгсэлд засвар хийсэн талаарх илтгэх хуудасыг 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулахыг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (Б.Оюутболд)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Д. МӨНХСАЙХАН

601210105